

**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ**



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧТАЙ
БАЙГУУЛАХ
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

2022 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2022 оны дугаар сарын

№

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, харьяа байгууллагуудын удирдах ажилтнуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэхэд оршино.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, болон холбогдох хууль, тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, нөгөө талаас **Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга С.Батжаргал** нар 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3. "Тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хугацаа, хариуцах нэгжийг тусгав.

1.4. Талуудын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн зохицуулна.

Хоёр. Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

2.1. Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд, Нийслэлийн Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангана.

2.3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, ёс зүй сахилга, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авна.

2.4. Харьяа байгууллагуудад төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохицуулалтаар хангана.

2.5. Төрийн худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангаж ажиллана.

2.6. Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхдээ тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзан дүгнэх, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллана.

2.7. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд нь олгоно.

2.8. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.9. Ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжиж, төсвийн сахилга батыг чангатган, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулж ажиллана.

Гурав. Удирдах ажилтны хүлээх үүрэг.

3.1. Хууль, дүрэм, энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө хариуцна.

3.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилтын хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.

3.3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.

3.4. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, алба хаагчдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.

3.5. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.

3.6. Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.

3.7. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.

3.8. Нийслэлийн удирдлагаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.

3.9. Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.

3.10. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.

3.11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.

3.12. Хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоол, 2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоол, 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоол, 2021 оны "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах" тухай 360 дугаар тогтоол, 2020 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" батлах тухай 206 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.

3.13. Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаал, өгсөн чиг үүргийн биелэлтийг хангаж, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн өмнө хариуцна.

3.14. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллана.

Дөрөв. Гэрээг дүгнэх

4.1. Энэхүү гэрээний биелэлтийн бүтэн жилийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

4.2. Гэрээний хавсралт болох "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлнэ.

Тав. Гэрээний хариуцлага

5.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй, гэрээний хавсралт болох “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээг дутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

Зургаа. Бусад зүйл


6.1. Гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.

6.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нэг талдаа бичгээр мэдэгдэнэ.

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд 1 хувийг тус тус хадгална.

Долоо. Гэрээ байгуулсан:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



НАЛАЙХЫН БАРИЛГЫН
МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН



SIGN HI

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ


Д.СУМЬЯАБАЗАР

Төлөвлөгөө баталсан:

Төсвийн Шууд захирагч

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

С.БАТЖАРГАЛ



“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
НЭГ. Зорилго 1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 3.2 Хотыг үйлдвэрлэл, инновацын төв болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.							
1	Зорилт 3.2.2. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг үе шаттайгаар байгуулна.						
1.1	Арга хэмжээ: 3.2.2.1. Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк -ийн дэд бүтцийг байгуулна. Ажлын хүрээнд 1.1.1 Цэвэрлэх байгууламж барих	Улс, нийслэлийн концесс, төр хувийн хэвшлийн түншлэл	Ажлын явц, хувь	Зураг төсөв хийгдсэн	30	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

	хөрөнгө оруулалтын асуудлыг холбогдох яамд, тамгын газарт хүсэлт гаргах, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж хүргүүлэх						
1.2	1.1.2 Паркийн дулааны станц, бусад дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах	Улс нийслэлийн концесс, төр хувийн хэвшлийн түншлэл	чанар	Зураг төсөв хийгдсэн	Хөрөнгө оруулалт татах ажлуудыг хийсэн байна.	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
<p>ХОЁР. Зорилго 2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 6.2. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.</p>							
Зорилт: 6.2.1. Дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.							
2.1	Арга хэмжээ: 6.2.1.6 Барилгын материалын бөөний худалдааны төвийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлэх.		хувь	60га газрын гэрээ, гэрчилгээ гарсан.	50	I-IV улирал	ХБХГ "НБМҮТП" ОНӨТҮГ
3	<p>ГУРАВ. Зорилго 3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 4.1. Мэдээлэл технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгох.</p>						
Зорилт: 4.1.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангах.							
3.1	Арга хэмжээ 1: 4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж		Санхүүгийн мэдээллийг шилэн дансанд байршуулсан тоо	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

	төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	-			дансны тухай хууль"-ийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.		
ДӨРӨВ. Зорилт 4. Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд							
4.1	110/10 кВ-ын 2х16 мВА чадалтай дэд станцын угсралтын ажлыг бүрэн дуусгах ажилд хяналт тавих.	3,578.2 /Нийслэлийн төсөв/	хувь	Барилгын ажил хийгдсэн	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.2	110 кВ-ын ЦДАШ-ын Барилга угсралтын ажлыг эхлүүлэх		хувь	ЦДАШ-ын ажил хийгдсэн	100	IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.3	Шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах.	-	тоо	41 ААН гэрээ байгуулсан	5	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.4	Гэрээний дагуу үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, хяналт үнэлгээ хийнэ.	-	тоо	10 ААН бүтээн байгуулалт аа эхлүүлсэн	5	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.5	Паркийн цэвэр ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж, УДДТ-үүдийн барилга байгууламжуудийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийг хийлгэх хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох газруудаар шийдвэрлүүлэх.	-	хувь	Ажлын даалгавар батлагдсан	40	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.6	Паркийн 250га талбайд техник технологийн түвшний ерөнхий үнэлгээ хийлгэх.	-	хувь	2016 онд "Мецачу" ХХК 120га талбайд хийсэн.	100	II-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

4.7	Байгууллагын Төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэвийн тасралтгүй явуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж өглөг авлагагүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	227,008.5 Нийслэлийн төсөв	хувь	НАГ-т 2016-2018 оны санхүүгийн тайланг шалгуулж зөрчилгүй санал дүгнэлт авсан.	100	II, IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.8	Мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын сайт, цахим хуудсуудад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол тавьж мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа хийх.	-	тоо	-	2	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.9	Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаархи мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах,	-	хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.10	Албан хэрэг хөтлөлтийн Эдок системд албан хаагчид зөрчил үүсгэхгүй, албан бичгийн норм стандартыг мөрдөх, хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

4.11	Иргэд, албан хаагчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх, шийдвэрлэлтийн мэдээ тайланг НЗДТГ-т хүргүүлэх	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.12	Албан хаагчдад үүссэн цаасан болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу хүлээн авч байгууллагын архивт бүрдүүлэлт хийх	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.13	Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуулийг баримтлан байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, болон хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж батлан мөрдөж ажиллах	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.14	Албан хаагчдыг чадавхижуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах	-	Сургалтанд хамрагдалт, хувь	100	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.15	Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар сурталчлах, албан хаагчдад мэдээлэл өгөх, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах	-	Хэрэгжилт хувь		100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ
4.16	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон MNS ISO 45001:2018 стандартыг мөрдүүлж ажиллах	-	Хэрэгжилт хувь		100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ

“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/Жилийн эцэс/

2022 оны 12-р сарын 07-ны өдөр

Налайх дүүрэг

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж	Биелэлт /хувь/
НЭГ. Зорилго 1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 3.2 Хотыг үйлдвэрлэл, инновацын төв болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.								
1	Зорилт 3.2.2. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг үе шаттайгаар байгуулна.							
1.1	Арга хэмжээ: 3.2.2.1. Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийг байгуулна. Ажлын хүрээнд 1.1.1 Цэвэрлэх байгууламж барих хөрөнгө оруулалтын асуудлыг холбогдох яамд, тамгын газарт хүсэлт гаргах, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж хүргүүлэх	Улс, нийслэлийн концесс, төр хувийн хэвшлийн түншлэл	Ажлын явц, хувь	Зураг төсөв хийгдсэн	30	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгжээр дамжин хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд “Европын сэргэн босголт, хөгжлийн банк”-ны санхүүжилтээр санхүүжүүлэхээр бичиг баримтын бүрдлийн ханган хүргүүлсэн.						

1.2	1.1.2 Паркийн дулааны станц, бусад дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах	Улс нийслэлийн концесс, төр хувийн хэвшлийн түншлэл	чанар	Зураг төсөв хийгдсэн	Хөрөнгө оруулалт татах ажлуудыг хийсэн байна.	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		26 МВт-ийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг барилга хот байгуулалтын яамны 2023 оны төсвөөр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлээд байна.						
ХОЁР. Зорилго 2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 6.2. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.								
2	Зорилт: 6.2.1. Дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.							
2.1	Арга хэмжээ: 6.2.1.6 Барилгын материалын бөөний худалдааны төвийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлэх.		хувь	60га газрын гэрээ, гэрчилгээ гарсан.	50	I-IV улирал	ХБХГ “НБМҮТП” ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		“Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв” байгуулах төслийг НБМҮТП-г түшиглэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах Тогтоол, захирамжийн хүрээнд 60 га талбайд Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хөрөнгө оруулалтын санал болон зураг төсөл гүйцэтгүүлэх саналыг НЗДТГ-т хүргүүлсэн.						
ГУРАВ. Зорилго 3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго: 4.1. Мэдээлэл технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгох.								
3	Зорилт: 4.1.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангах.							
3.1	Арга хэмжээ 1: 4.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн		Санхүүгийн мэдээллийг шилэн дансанд байршуулсан тоо	Шилэн дансны тухай хуулийн	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100

	хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	-		хэрэгжилтийг хангаж ажилласан.	байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.				
Гүйцэтгэл:		Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын хүрээнд байгууллагаас гаргасан аливаа тушаал, шийдвэр, гэрээ хэлцэл, төсөв хөрөнгө захиран зарцуулах болон байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт, санхүүгийн тайлан мэдээ, орлого, зарлага, санхүүжилт, өндөр дүнтэй гүйлгээ зэрэг бүх мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан. Хагас жилийн байдлаар нийт 20 төрлийн мэдээг сар бүр мэдээллэсэн.							
ДӨРӨВ. Зорилт 4. Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд									
4.1	110/10 кВ-ын 2х16 мВА чадалтай дэд станцын угсралтын ажлыг бүрэн дуусгах ажилд хяналт тавих.	3,578.2 /Нийслэлийн төсөв/	хувь	Барилгын ажил хийгдсэн	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100	
Гүйцэтгэл:		Үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтад 2022 онд нийслэлийн төсвөөс 3,578,2 сая төгрөг тусгагдсан бөгөөд төсвийн тодотголоор 1,000,0 сая төгрөг нь хасагдан 1,500 сая төгрөгийг урьд онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилтэд суутгагдсан. Үлдэгдэл 580,8 сая төгрөгөөр Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч “Вилл вест” ХХК нь 110/10 кВ-ын дэд станцын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн тоног төхөөрөмжийн суурь, 10 кВ-ын 13,8 км кабель шугамын угсралтын ажлыг бүрэн дуусгасан ба “10 кВ-ын хуваарилах байгууламж”-ийн тоног төхөөрөмж, материалын захиалгыг хийж урьдчилгаа төлбөрөө төлсөн боловч төлбөрөө бүрэн хийх хөрөнгийн эх үүсвэргүйн улмаас татан авалтын ажил зогссон.							
4.2	110 кВ-ын ЦДАШ-ын Барилга угсралтын ажлыг эхлүүлэх.	-	хувь	ЦДАШ-ын ажил хийгдсэн	100	IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	50	
Гүйцэтгэл:		Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх хүсэлтийг НЗДТГ-т хүргүүлсэн бөгөөд 2022 оны төсвийн тодотголоор үндсэн цахилгаан хангамжийн санхүүжилт хасагдан бүтээн байгуулалт хийгдээгүй.							

4.3	Шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах.	-	тоо	41 ААН гэрээ байгуулсан	5	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 37 аж ахуйн нэгж паркт байрших хүсэлт ирүүлсэн ба тэдгээрийн төсөл, байгаль орчинд ээлтэй, хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, шинэ технологийн талаарх мэдээллийг судалж дүгнэлтийг гарган 26 аж ахуйн нэгжтэй шинээр хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд 6 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа явуулах гэрээг сунган ажиллаж байна.						
4.4	Гэрээний дагуу үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, хяналт үнэлгээ хийнэ.	-	тоо	10 ААН бүтээн байгуулалт аа эхлүүлсэн	5	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Паркийн 250 га газар дээр нийт 50 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 46 аж ахуйн нэгжтэй гэрээ дүгнэн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, бичиг баримт, зураг төслийн бүрдлийг хангах шаардлага хүргүүлсэн. 10 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа барин үйлдвэрийн барилга байгууламжаа барих бэлтгэл ажлыг хангаад байна. 2 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд Налайх дүүргээс 18 иргэнийг түр ажлын байраар ханган, барилга угсралтын ажил 30%-тай явагдаж байна. 5 аж ахуйн нэгжид үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардлагатай цахилгаан хангамжийн түр тэжээлээр хангаад байна.						
4.5	Паркийн цэвэр ус, дулаан хангамж, цэвэрлэх байгууламж, УДДТ-үүдийн барилга байгууламжуудийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийг хийлгэх хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох газруудаар шийдвэрлүүлэх.	-	хувь	Ажлын даалгавар батлагдсан	40	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	50
Гүйцэтгэл:		Паркийн дэд бүтцийн барилга, байгууламжуудийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ, БХБЯ болон холбогдох газруудад хүсэлт гаргасан.						

4.6	Паркийн 250га талбайд техник технологийн түвшний ерөнхий үнэлгээ хийлгэх.	-	хувь	2016 онд “Мецачү” ХХК 120га-д хийсэн.	100	II-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь хэсгийн дагуу техник технологийн түвшний үнэлгээг боловсруулах 45 сая төгрөгийн төсвийг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх зураг төслийн саналд хүргүүлсэн боловч хөрөнгө оруулалт тусгагдаагүй. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдан 2022.08.01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх болсонтой холбоотойгоор техник технологийн түвшний үнэлгээг хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын дагуу боловсруулахаар болсон.						
4.7	Байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэвийн тасралтгүй явуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж өглөг авлагагүй ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	301,844.7 Нийслэлийн төсөв	хувь	НАГ-т 2016-2018 оны санхүүгийн тайланг шалгуулж зөрчилгүй санал дүгнэлт авсан.	100	II, IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Санхүүгийн тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бүртгэж хөтлөх, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бодитой тайлагнаж байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж нөхцөлөөр ханган анхан шатны болон бусад баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, холбогдох тайланг бэлтгэн ажиллаж байна. Шинээр өр төлбөр үүсээгүй.						
4.8	Мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын сайт, цахим хуудсуудад үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол тавьж мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа хийх.	-	тоо	-	2	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100

Гүйцэтгэл:		<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын вэб сайт, пэйж хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны ил тод байдал, - Хүний нөөцийн ил тод байдал, - Төсөв, санхүүгийн ил тод байдал, - Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн дөрвөн төрлөөр мэдээ мэдээллүүдийг тогтмол болон цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна. 						
4.9	Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаархи мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах,	-	хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		<p>2022 онд</p> <ul style="list-style-type: none"> - Гадаад томилолт – 1, - Зочид төлөөлөгчид – 5, - Албан уулзалт – 4, - Олон улсын цахим хурал – 1, - Гэрээ, санамж бичиг – 1 тус тус хийгдэж, тухай бүрт нь байгууллагын үйл ажиллагааны болон, шаардлагатай хөрөнгө оруулалт, цаашид хийгдэх ажлын тухай мэдээллийг танилцуулж, хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлж ажилласан. - БНХАУ, БНСУ, ХБНГУлсуудын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчидтэй түлхүү холбогдож ажиллалаа. 						
4.10	Албан хэрэг хөтлөлтийн Эдок системд албан хаагчид зөрчил үүсгэхгүй, албан бичгийн норм стандартыг мөрдөх, хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллах	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100

Гүйцэтгэл:		Эдок системд жилийн эцсийн байдлаар албан хаагчдаас гаргасан зөрчил байхгүй бөгөөд албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 4,5 байна. Шинэчлэгдэн гарсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу баримт бичгийг боловсруулан ажиллаж байна. Хэвлэмэл хуудсын ашиглалт зарцуулалтын мэдээг улирал бүр гарган, хагас бүтэн жилээр даргын тушаалаар үргүй зарцуулсан хэвлэмэл хуудсыг хүчингүй болгож байна. Мөн даргын 2022 оны А/03 тушаалаар “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ыг, А/11 тушаалаар “Хэвлэмэл хуудасны индекс”-ийг тус тус шинэчлэн баталсан. Хэвлэмэл хуудсыг шинэчлэгдсэн стандартаар боловсруулан НАГ-ын мэргэжилтнээр хянуулж байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна.						
4.11	Иргэд, албан хаагчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх, шийдвэрлэлтийн мэдээ тайланг НЗДТГ-т хүргүүлэх	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Иргэдээс ирүүлсэн 2, албан хаагчдаас ирүүлсэн 23 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, тайлан мэдээг улирал бүр НЗДТГ-ын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлж байна. Шийдвэрлэлтийн дундаж хоног 5 өдөр. Шийдвэрлэлтийн тайлан, мэдээг байгууллагын даргын дэргэдэх байнгын зөвлөлийн хуралд танилцуулан ажилласан.						
4.12	Албан хаагчдад үүссэн цаасан болон тусгай төрлийн баримтыг хуваарийн дагуу хүлээн авч байгууллагын архивт бүрдүүлэлт хийх	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Байгууллагын архивын төлөвлөгөө, архивт баримт хүлээн авах хуваарь, 2022 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлан хуваарийн дагуу албан хаагчдаас цаасан болон тусгай төрлийн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийж данс бүртгэлийг шинэчлэн үйлдсэн. Архивын өрөөний чийгшил, цэвэрлэгээ үйлчилгээ, түр олгосон баримтын бүртгэл, хуулбар олгосон баримтын бүртгэл зэрэг шаардлагатай бүх бүртгэлийг тухай бүр нь хөтөлж байна. Мөн газрын даргын 2021 оны захирамжлалын цахим баримтыг архивын дэд системд бүртгэн нийслэлийн Архивын газарт цахим тээгчид буулган хүлээлгэн өгсөн. 2023 онд төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу бэлтгэл байдлыг хангасан.						

4.13	Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуулийг баримтлан байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, болон хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулж батлан мөрдөж ажиллах	-	Хэрэгжилт хувь	-	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг даргын 2022 оны А/01 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, хөдөлмөрийн гэрээний холбогдох зүйл заалтад өөрчлөлт оруулан албан хаагчидтай байгуулсан.						
4.14	Албан хаагчдыг чадавхижуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах	-	Сургалтанд хамрагдалт, хувь	100	100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		<p>Дүүрэг, нийслэл болон холбогдох газруудаас зохион байгуулсан 12 сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг хамруулсан</p> <ul style="list-style-type: none"> • НД-ийн Татварын хэлтэс-Хөрөнгө орлогын мэдүүлэг – 12 албан хаагч • НЗДТГ- Нийслэл RISE-Academy сургалт – 1 • НД-ийн Цэцэрлэгжүүлэлтийн алба – Агротехникийн мэдлэг олгох сургалт – 2 • НБИХГ-Төр хувийн хэвшлийн түншлэл сургалт, хэлэлцүүлэг – 5 • НАГ- Албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журмыг танилцуулах сургалт – 1 • НАГ- Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагуудад чиглэл олгох сургалт – 1 • НӨХГ –Төрийн өмчийн тооллогын системийн сургалт – 2 • НЗДТГ- Нийслэл 110 Менторшип хөтөлбөр – 1 • НЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс-Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын тухай – 2 • НАГ-Шинээр томилогдсон албан хаагчдад ААХХ-ийн мэдлэг олгох сургалт – 2 • НЗДТГ, “Легал линк си би эй”-FIDIC-ийн жишиг гэрээ, түүний онцлог сургалт – 1 • НЗДТГ, Удирдлагын академи–Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхижуулах нь сургалт – 1 • НЗДТГ-ын Хөгжүлийн бодлого, төлөвлөлтөлийн хэлтэс-"Улс, нийслэлийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан бичиг баримт боловсруулах нь" сэдэвт сургалт -1 • Нийслэл дэх Жендерийн салбар хороо – “Жендэр ба хүний эрх” сургалт – 1 • НЗДТГ – “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх” сургалт – 2 						

		<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газар - Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд боловсруулсан эрх зүйн баримт бичиг, шинэчилсэн стандартыг танилцуулах, Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад мэдээлэл өгөх, хэвлэмэл хуудас ашиглах заавар, зөвлөгөө – 1 • НЗДТГ – “HR-2022” чуулга – 1 <p>Дотоод сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Албан бичиг, тайлан, төлөвлөгөө, түүний биелэлт гаргах • Эдокийн боловсруулалт цэсээр албан бичиг боловсруулах талаар зохион байгуулж давхардсан тоогоор 14 албан хаагч оролцсон. <p>Ажилтнуудад хууль, эрхзүйн мэдлэг олгох үүднээс "Хуулийн цаг" мэдээллийн цагийг зохион байгуулж дараах чиглэлээр 4 удаа мэдээллийг өгсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Шилэн дансны тухай хууль • Үйлдвэр технологийн эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан өөрчлөлт орсон зүйл заалтын талаар, • Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III-ыг хэрэгжүүлэх зорилго зорилтыг паркт хэрхэн уялдуулах талаар, <p>Төсвийн хэмнэлтийн хуулийн мэдвэл зохих зүйл заалтуудын талаар тус тус мэдээлэл хийж давхардсан тоогоор 34 албан хаагч хамрагдсан. Дээрх сургалтуудад нийт 107 албан хаагч хамрагдсан.</p>						
4.15	Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар сурталчлах, албан хаагчдад мэдээлэл өгөх, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах	-	Хэрэгжилт хувь		100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, тус биелэлтийг хагас болон бүтэн жилээр гаргаж, холбогдох дээд байгууллагад хүргүүлж ажилласан. Тухайн жилд албан хаагчдад мэдээлэл хүргэх сургалт – 2, цахим хуудсаар сурталчилгаа мэдээлэл – 6-г хүргэж, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд ажилтан, албан хаагчдыг уриалж, оролцуулсан.						

4.16	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон MNS ISO 45001:2018 стандартыг мөрдүүлж ажиллах	-	Хэрэгжилт хувь		100	I-IV улирал	НБМҮТП ОНӨТҮГ	100
Гүйцэтгэл:		MNS ISO 45001 : 2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо – Шаардлага, хэрэглэх зааврыг байгууллагын хэмжээнд баримтлан ажиллаж байна. Шинэчлэгдсэн Хөдөлмөрийн гэрээний 2.3.2, 2.3.4, 2.4.3 – т хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрх, үүргийн талаар тусгасан. Байгууллагын ХАБЭА-н стандартыг мөрдөх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг гаргасан.						
ГҮЙЦЭТГЭЛ		95 %						